

БАЯННУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Аудитынтайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахимхаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахимхаяг:

Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524
Цахимхаяг:

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитынгазар

Байршил: Аймгийн ЗДТГ-
ын байр, 1-р давхар

Цахим хуудас:

www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитынгэрчилгээ
Хавсралт 3: Менежментийнзахидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 28-наас 2 дугаар сарын 07-ны хооронд хийхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа аймаг дах Төрийн аудитын газарт 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/05 тоот албан бичгээр ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 21-наас 2 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэнэ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь Монгол улсын Төсвийн тухай тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 1-р зүйлд “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Бусад төсвийн байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны төсвийг Аймгийн ТЭЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Баяннуур сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 5 чиглэлээр 8 эрсдэлтэй асуудалд 14 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус Эрүүл мэндийн төв нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт сул байна.

Тус сургуулийн нягтлан бодогчоор 1-5 дугаар сард Т.Муратхан, 6-9 дугаар сард К.Байболат, 6-12 саруудад М.Хонай нягтлан бодогчоор ажилласан

байна.Төсвийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас Баяннуур сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн нь 2017 онд 351,1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 351,1 сая төгрөгийн, НДСангаас 6,5 сая төгрөгийг тус тус санхүүжилт авч, 357,6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуул сан байна.

Нийт төсвийн 71,3 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 3,2 хувийг тогтмол зардал, 6,1 хувийг хангамж бараа материалын зардал, 10,1 хувийг норматив зардал, 2,4 хувийг урсгал шилжүүлэг, 6,9 хувийг бусад зардал эзэлж байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн бүтэц орон нийт орон тооны хязгаарыг 29 ээр баталсан ба, гүйцэтгэлээр 35 орон тоогоор багтаан ажиллуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдоогүй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны батлагдсан төсвийг shilendans.gov.mn вэб сайтад байршуулсан байна.Төсвийн талаарх мэдээллийг байгууллагын самбарт байршуулжээ.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллага шилэн тухай хуулийн 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.4.5 -д заасан заалтуудыг зөрчсөн 358,6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг 2017.12.15 №274 тоот албан тоотой авч хангуулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого, санхүүжилт, цалин, НДШимтгэл, ХХОАТ, түлш халаалт, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал, хоолны зардал, үдийн цайны зардал, бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгасан

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой дараах материаллаг дараах алдаа зөрчил илрэв. Үүнд:

1. 2017 онд эм ханган нийлүүлсэн 5 компаниас худалдан авсан эмийн тооцоог хийж үзэхэд нийт дүнгээр 26.0 сая төгрөгийг шилжүүлж, 20.2 сая төгрөгийн эмийг орлого авсан тооцоо гарч байгаа боловч Мөнхийн тун ХХК, Эм хангамжийн ХХК-аас бусад компаниудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй тул үлдэгдлийг авалага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байна.

2. Цалингийн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр нийт цалин 243.3 сая төгрөг гарсан бөгөөд санхүүгийн тайланд тусгасан нийт цалин 229.7 сая төгрөг 13.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

3. Жилийн эцэст тооллого хийсэн материал ирүүлээгүй тул аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тооллогын дүнтэй тулган баталгаажуулах боломжгүй байна.

3. Хоолны зардлын төсвөөс 815.4 мянган төгрөг, эмийн зардлын төсвөөс 2668.1 мянган төгрөг, түлш шатах тослох материалын зардлын төсвөөс 509.8 мянган төгрөг бүгд 3993.6 мянган төгрөгийг Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан

Дээрхи алдаа зөрчлүүд нь Дээрхи алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох

бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 42.4-д “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалт хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна”,

Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2013 оны “Журам батлах тухай” 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Төсвийн захирагчийн зохицуулалт хийх журам”-ын 5.2 дах заалт, УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолын 3-ийн 1 дэх заалт болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудад тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тооллогыг заавал хийж тооцоог бодох, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлайнг үнэн зөв гаргах батлагдсан төсвийн зардлын бүлэг хооронд Төсвийн ерөнхийлөн захирагчийн зохих зөвшөөрөлгүйгээр дур мэдэн гүйлгэн зарцуулалт хийж, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөрчлийг арилгахыг албан шаардлагаар үүрэг бодов.

6. Байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан хавсралтанд заасан ажилтанд Засгийн газраас олгосон 243,0 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг олгосон байна.

Дээрхи алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-т “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар “Урамшуулал олгох тухай” тэмдэглэлд “УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчид 300000 төгрөгийн урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох

хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захиргч нарт даалгав” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс зориулалт бус зарцуулсан дээрхи зөрчлүүдийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Аудитаар материаллаг бус дараах алдаа, зөрчил илрэв.Үүнд:

1.2017 оны төсөвт орон тооны хязгаарыг 29-ээр баталсан ба гүйцэтгэлээр 35 орон тоог цалингийн санд багтаан ажиллуулж, 6 орон тоог илүү ажиллуулсан байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Байхгүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус байгууллага нь цалинтэй холбоотой материал болон авлага, өглөгийн тооцоо нийлсэн актуудыг аудитад бүрэн ирүүлээгүйгээс тайлант оны авлага, өглөг болон зарим зардлын нийт дүнг баталгаажуулах хангалттай нотлох зүйл цуглуулах боломж бүрдээгүй, аудитын хамрах хүрээ хязгаарлагдсан тул гүйцэтгэлийн аудитаар дахин шалгах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн маягтаар нэгтгэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн тайланд зөвлөмж өгөгдөөгүй байна

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, менежментийн захидал ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо: 2018.02.28

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо:2018.02.28

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Х.МАНАРГҮЛ
Огноо: 2018.02.28